

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ДОТООД АУДИТЫН АЛБА**



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

**Аудитын нэр: 17 СУМЫН ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Аудитад хамрагдсан жил: 2022-2023

**АУДИТ ХИЙСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

АУДИТ ХИЙГДСЭН БАЙГУУЛЛАГА: СЭЛЭНГЭ АЙМГИЙН 17 СУМ

АУДИТ ХИЙГДСЭН ОБЪЕКТ: ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САН

АУДИТЫН ТӨРӨЛ: ГҮЙЦЭТГЭЛИЙН

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2024.02.06-2024.06.14

АУДИТАД ХАМРАГДСАН ХУГАЦАА: 2022-2023

Тайланг бэлтгэсэн:

**Дотоод аудитын нэгжийн
удирдлагын дарга**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
дэргэдэх Санхүүгийн хяналт,
дотоод аудитын албаны дарга,
СХШУАБ Т.Одсүрэн

Аудитын багийн ахлагч :

Ахлах дотоод аудитор,
Т.Мөнхзул

Аудитын багийн гишүүн:

Дотоод аудитор, СХШУБ
Ц.Уртнасан
Дотоод аудитор Х.Батбаатар,

Огноо: 2024 оны 06 дугаар
сарын 14 өдөр

Сүхбаатар сумын 2 дугаар баг.
Нутгийн удирдлагын II байр
sankhuu_audit_se@yahoo.com

1. ТАНИЛЦУУЛГА

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ,

- 2.1. Аудитын зорилго**
2.2 Аудитын цар хүрээ
2.3. Аудитын арга аргачлал, хязгаарлалт

3. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА

- 3.1 Засаглалын талаар**
3.2 Эрсдэлийн удирдлагын талаар
3.3 Дотоод хяналтын талаар

4. АУДИТЫН ҮР ДҮН

- 4.1 Илэрсэн асуудлууд**

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

- 5.1 Цаашид авах арга хэмжээний санал**

1. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10¹, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3² дахь хэсгийн үндэслэн аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 тоот удирдамжийн хүрээнд 17 сумын Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэн тайланг танилцуулж байна.

Дотоод аудитыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2022 – 2023 оны үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

2. ДОТООД АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ.

2.1 Дотоод аудитын зорилго

Дотоод аудитын үйл ажиллагааг санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн аудитын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ба Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралт “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын холбогдох 42 заалтын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлэн, байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дүгнэлт гаргав.

2.2 Дотоод аудитын бүрэлдэхүүн, хугацаа.

Сэлэнгэ аймгийн 17 сумын “Хоршоо хөгжүүлэх сан”-ийн 2022-2023 оны үйл ажиллагаанд хийсэн аудитад багийн ахлагчаар Ахлах дотоод аудитор Т.Мөнхзул гишүүдэд Дотоод аудитор Ц.Уртнасан, Дотоод аудитор Х.Батбаатар нар ажиллаа.

¹ “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”;

² “Аймаг, нийслэлийн Засаг дарга нь сум, дүүрэг, харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэл санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх арга хэмжээ авах”

2.3 Дотоод аудитын цар хүрээ.

Шалгалтад 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ийг дуусталх хугацааны “Хоршоог хөгжүүлэх сан”-тай холбоотой эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн хурлын тэмдэглэл, “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу шаардлага хангасан зээлдэгчийн хувийн хэрэг, зээлдэгчийн зээлийн гэрээ болон барьцааны гэрээ, зээлийн олголт, эргэн төлөлтийн тайлан тэнцэл, бусад холбогдох санхүүгийн үндсэн баримтууд хамрагдлаа.

Дотоод аудитад дараах асуудлыг хамруулан шалгасан ба аудитын хамрах хүрээний хязгаарлалтыг дор тодотгож өгөв.

1. “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын хэрэгжилт;
2. Сангаас иргэн, хуулийн этгээдэд олгосон хөнгөлөлттэй зээл нь зориулалтын дагуу эсэх;
3. Хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд алданги ногдуулсан эсэх;
4. Хууль тогтоомжид заасан бусад эрх, үүргийн биелэлт

Аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

Хоршоог хөгжүүлэх сангийн 2022-2023 оны үйл ажиллагааны хамрах хүрээнд хязгаарлалт байхгүй болно.

Аудитын арга аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын баталсан 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ыг удирдлага болгон үйл явцын мөрөөр хөөн шалгах хяналтын горимыг сонгон холбогдох ажилтан, албан хаагчид, төсөл ирүүлэгч нартай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, “Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах хороо”-ны үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

Үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас өгсөн албан шаардлага, зөвлөмж, тэдгээрийн хэрэгжилт, илэрсэн зөрчлийн байдалд өгсөн дүгнэлт зэргийг үнэлэн эрсдэлийг тогтоож, түүнд хяналт шалгалтыг чиглүүлсэн ба аудитаар илэрч буй асуудлууд нь хэрхэн арилахгүй, давтагдаж буй учир шалтгааныг тодруулан, “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн анхан шатны баримт, нотломжид тулгуурлан нягтлан шалгав.

Мөн дээрх горимыг ашиглахдаа Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 6.1-д заасан эрхийн хүрээнд холбогдох албан хаагчтай уулзалт, ярилцлага хийсэн болно. Үүнд:

а/Дотоод аудитаар байгууллагын удирдлагад дотоод аудитын зорилго, хэрэгжүүлэх зарчмыг танилцуулан, засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны талаарх болон илэрсэн асуудлын хүрээний талаарх асуулга авсан.

б/Мөн аудитын хамрах хүрээнд багтаасан асуудлуудаар байгууллагаас ирүүлсэн бичиг баримтад дүн шинжилгээ хийсэн. Аудитын эдгээр горимын үр дүнд аудитын баг хангалттай нотолгоо цуглуулж, аудитын дүгнэлтээ гаргасан болно.

Дотоод аудитын үйл ажиллагааг Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартад нийцсэн санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан стандарт, арга зүйн хүрээнд явуулсан.

Дотоод аудитад дараах хууль, эрхзүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын Үндсэн хууль
- Иргэний хууль
- Төсвийн тухай хууль
- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль
- Зээлийн мэдээллийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Засгийн газрын тогтоол, холбогдох журам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”

3. БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, САЙН ТУРШЛАГА

3.1 Дотоод аудитад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл, танилцуулга.

17 сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн “Хоршоог хөгжүүлэх сан”-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтад хамрагдсан хугацааны хөрөнгө мөнгө захиран зарцуулалт, зээл олголтын байдлыг авч үзвэл:

1.Зээл олголт, /мянган төгрөг/

Сумын нэр	Зээлдэгчийн тоо	Үндсэн зээл	Хүү	Тооцсон алданги	Дутуу тооцоолсон алданги	нийт дүн
Алтанбулаг	16	131 189.3	3 419.3	8 874.7	2 741.3	146 224.6
Баруунбүрэн	18	148 959.3	6 345.5		0.0	155 304.8
Баянгол	20	255 510.9	13 596.6	840.3	0.0	269 966.5
Ерөө	47	367 283.8	21 993.1	300.0	17 544.5	407 121.4
Жавхлант	13	95 409.1	4 321.2	97.2	0.0	99 827.5
Зүүнбүрэн	20	109 656.5	2 082.6		0.0	111 739.1
Мандал	133	853 919.2	35 372.1		6 238.7	895 530.0
Орхон	14	204 779.4	6 516.1		0.0	211 295.5

Орхонтуул	17	197 699.8	12 893.2	2 205.1	0.0	212 798.1
Сайхан	56	366 207.7	22 650.1	441.9	8 157.8	397 015.6
Сант	20	187 595.5	8 009.6	7 026.3	0.0	202 631.4
Сүхбаатар	140	931 724.8	38 523.3		178 958.7	1 149 206.8
Түшиг	22	129 403.4	5 884.6		1 819.0	137 107.0
Хушаат	19	162 953.3	13 613.3		0.0	176 566.6
Хүдэр	32	157 830.9	6 153.0		0.0	163 983.9
Цагааннуур	18	175,938.9	9 392.9		2 198.5	187 530.3
Шаамар	35	153 533.0	9 942.0		29 747.1	193 222.1
Дүн	640	4 629 594.8	220 708.5	19 785.5	247 405.6	5 117 494.4

2.Зээл олголт, чанаргүй зээл /мянган төгрөг/

Сумын нэр	Нийт олгосон зээл		Чанаргүй зээл	
	Зээлдэгчийн тоо	Зээлийн үлдэгдэл	Зээлдэгчийн тоо	Зээлийн үлдэгдэл
Алтанбулаг	16	146 224.6	16	146 224.5
Баруунбүрэн	18	155 304.8	14	34 750.6
Баянгол	20	269 966.5	3	24 312.8
Ерөө	47	407 121.4	34	288 279.4
Жавхлант	13	99 827.5	10	35 438.5
Зүүнбүрэн	20	111 739.1	12	23 628.8
Мандал	133	895 530.0	96	565 913.0
Орхон	14	211 295.5	4	23 521.9
Орхонтуул	17	212 798.1	17	212 798.1
Сайхан	56	397 015.6	38	137 125.3
Сант	20	202 631.4	12	41 388.3
Сүхбаатар	140	1 149 206.8	110	870 630.1
Түшиг	22	137 107.0	16	81 679.9
Хушаат	19	176 566.6	13	67 761.0
Хүдэр	32	163 983.9	12	38 690.6
Цагааннуур	18	187 530.3	15	92 991.7
Шаамар	35	193 222.1	33	186 942.9
Дүн	640	5 117 494.4	455	2 872 077.3

17 сумын “Хоршоог хөгжүүлэх сан”-д 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 640 зээлдэгчийн 5,117,494.4 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 455 зээлдэгчийн 2,872,077.3 буюу нийт олгосон зээлийн 56.1 хувь нь чанаргүй зээл байна.

Тайлант хугацаанд буюу 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нэгдүгээр гарын үсгийг сумын Засаг дарга, хоёрдугаар гарын үсгийг сангийн нягтлан бодогч нар зурж ирсэн ба төрийн санд байрлах Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны дансаар ажил гүйлгээгээ гүйцэтгэж ирсэн байна.

Сэлэнгэ аймгийн 17 сумын Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалтаар Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэл болон санхүүгийн тайлангийн авлагын дэлгэрэнгүй бүртгэлд хэрэглэгч тус бүрээр үүсгэж зөрүүгүй тайлагнасан Баянгол, Зүүнбүрэн, Орхон, Сант сумууд байгааг онцлох нь зүйтэй юм.

3.2 Байгууллагын засаглал, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын талаар:

Засаглалын удирдлага

Аймгийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг ханган, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилго, орон нутгийн хэмжээнд түүхий эдийн нөөц, хүн амын эрэлт хэрэгцээтэй байдлыг үндэслэн төслийг сонгон шалгаруулж зээл олгож байгаа боловч эрэн төлөлт, барьцаа хөрөнгийн шаардлага хангуулах, мэргэжил арга зүйгээр хангах, сангийн хөрөнгөд хяналт тавих чиг үүргийг оновчтой тодорхой болгон ажиллах шаардлагатай байна.

Иймд сумдын Засаг дарга нарт Сангийн хөрөнгийн журмын хэрэгжилтийг хангах, удирдлага зохион байгуулалтыг сайжруулж ажиллахын тулд хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, шаардлагатай дэмжлэг үзүүлэхийг сумдын Засаг дарга нарт зөвлөмж байна.

Эрсдэлийн удирдлага

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” -ын хэрэгжилтийг хангах явцад үүсэж болох эрсдэл болон өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийн хуваарь, гэрээний хэрэгжилтийг хангахад үүсэх эрсдэлийн удирдлагын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж эрсдэлийг бүртгэх тогтолцоог бүрдүүлээгүйгээс сангийн хөрөнгийн 56.1 хувь хугацаа хэтэрсэн, зээлийн муу ангилалд орсон байна.

Цаашид сангийн хөрөнгийн үр ашигтай байдлыг сайжруулах муу зээлийн ангиллыг бууруулахад чиглэсэн эрсдэлийн удирдлагын үйл явцыг сайжруулах чиглэлээр сангийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа эрсдэлүүдийг бүртгэх, цаашид шинээр үүсэж болох эрсдэлүүдийг урьдчилан хянах тогтолцоог бий болгож ажиллахыг сумдын Засаг дарга нарт зөвлөмж байна.

Дотоод хяналт

“Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий хяналтын зөвлөл” нь төсөл сонгон шалгаруулах үйл явц дээр хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн, заавар журмын дагуу зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Иймд дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Дээд болон гүйцэтгэх удирдлага байгууллагын бүх түвшинд дотоод хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай стандарт, бүтэц үйл явцыг ойлгуулах
- Дотоод хяналтын бодлого, дүрэм журмыг боловсруулан мөрдөж ажиллах
- Сангийн хөрөнгөөс олгосон зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих зорилгоор олон нийтэд ил тод мэдээлж байх.
- Дотоод хяналтын сул талуудыг үнэлж, үр дүнг засаглах ба гүйцэтгэх удирдлагад мэдээлж байх.

4.АУДИТЫН ҮР ДҮН

4.1 Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны талаар буюу санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, үр ашгийн байдал

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулсан байдал:

4.2 Дотоод аудитаар тогтоосон нөхцөл байдал, илэрсэн асуудал, зөрчил, дутагдал, гарсан шалтгаан, шийдвэрлэсэн асуудлууд.

Илэрсэн асуудал 1.	ХХС-ийн зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн үлдэгдэл санхүүгийн тайлангийн дүнгээс зөрүүтэй байна. Үүнд ХХС-ийн зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн үлдэгдэл 196,833.8 мянган төгрөгөөр илүү, 44,713.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн.
Асуудлын ангилал	Их
Бодит байдал	<p>17 сумын ХХС-ийн зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2023 оны жилийн эцсийн үлдэгдэл санхүүгийн тайлангийн дүнгээс нийт 196,833.8 мянган төгрөгийн илүү дүнгээр илэрхийлэгдсэн дараах 8 сумын сангууд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Баруунбүрэн – 7,521.9 мянган төгрөг - Баянгол - 12,859.3 мянган төгрөг - Ерөө - 16,162.5 мянган төгрөг - Мандал - 10,034.2 мянган төгрөг - Орхонтуул - 12,625.2 мянган төгрөг - Сүхбаатар - 125,740.8 мянган төгрөг - Хушаат - 129.7 мянган төгрөг - Цагааннуур - 11,759.7 мянган төгрөг <p>Харин дараах 6 сумын ХХС-ийн зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн үлдэгдэл санхүүгийн тайлангийн дүнгээс нийт 44,713.3 мянган төгрөгөөр дутуу дүнгээр илэрхийлэгдсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Алтанбулаг - 114.3 мянган төгрөг - Жавхлант - 81.4 мянган төгрөг - Сайхан - 18,566.3 мянган төгрөг - Түшиг - 18,315.5 мянган төгрөг - Хүдэр - 514.2 мянган төгрөг - Шаамар - 7,121.7 мянган төгрөг
Байх ёстой шаардлага /шалгуур	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах"
Асуудлын шалтгаан үндсэн	ХХС-ийн зээлийн мэргэжилтэн болон нягтлан бодогч нар зээлийн эргэн төлөлтийг зээлдэгч тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс зээлийн эргэн төлөлтийг системд бүртгэхдээ үнэ зөв бүртгээгүйгээс шалтгаалж 2 системийн мэдээллүүд хоорондоо зөрүүтэй тайлагнагдсан байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Санхүүгийн тайлан мэдээ буруу илэрхийлэгдэх, сангийн үр ашиггүй байдал нь алдагдал хүлээх үр дагавартай.
Зөвлөмж	Харилцагч тус бүрээр авлагын дүнг тулган баталгаажуулж бүртгэлийн зөрүүг залруулах.
Илэрсэн асуудал 2.	Санхүүгийн тайлангийн программд зээлдэгчийн авлагыг бөөн дүнгээр бүртгэсэн.
Асуудлын ангилал	Их
Бодит байдал	Санхүүгийн тайлангийн программд 552 зээлдэгчийн 4,081,732.5 мянган төгрөгийн авлагыг бөөн дүнгээр бүртгэж авлага ба төлбөрийн тооцоог хянаж баталгаажуулаагүй байгаагаас шалтгаалан зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэл зөрсөн, сангаас зээл авсан харилцагчийн зээлийн эргэн төлөлт үнэн зөв тайлагнагдаагүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах", 20.2.6-д "...үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах,..." гэсэн заалтуудыг зөрчсөн.
Асуудлын шалтгаан үндсэн	<p>1. Сангийн нягтлан бодогч, зээлийн мэргэжилтэн хоёр зээлийн эргэн төлөлтийг харилцагч тус бүрээр тулган тооцооллыг хийдэггүй,</p> <p>2. Сангийн нягтлан бодогч санхүүгийн тайлангийн программ хангамжид зээл авсан харилцагчийг тус бүрээр бүртгээгүйгээс зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн системийн мэдээлэлтэй зөрсөн.</p> <p>3. Албан тушаалтнууд хариуцсан ажлыг чиг үүргээ ухамсарлаагүй. Хууль тогтоомжийн хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаагүй</p> <p>4. Сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч нарыг тогтвортой ажиллуулаагүй, мэргэжлийн бус хүнээр сангийн мэргэжилтэн хийлгэсэн</p> <p>5. Сангийн хөрөнгийн орлого төвлөрүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй зэргээс тус тус шалтгаалсан байна.</p>
Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Сангийн хөрөнгө бүрэн төвлөрөхгүй байх
Зөвлөмж	Санхүүгийн программд харилцагч тус бүрээр тооцоо нийлж баталгаажуулсан дүнгээр зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн дүнтэй тааруулж авлагын бүртгэлийг харилцагч тус бүрээр задалж бүртгэх.
Илэрсэн асуудал 3.	Зээлдэгчийн хугацаа хэтэрсэн зээлд алдангийг тооцоогүй.

Асуудлын ангилал	Их
Бодит байдал	11 суманд нийт 222 зээлдэгчийн хугацаа хэтрэлтийн алдангийг тооцоогүй байгаа нь гэрээний хэрэгжилтийг хангахгүй сангийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.
Байх ёстой шаардлага /шалгуур	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, ...", ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалын 2.6-д "Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол зээлийн үлдэгдлээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд алданги ногдуулах ба алдангийн хувь хэмжээ, нөхцөлийг сумын Засаг дарга, зээлдэгч нарын хооронд байгуулах гэрээнд заавал тусгана".
Асуудлын шалтгаан	үндсэн Зээлийн мэдээллийн нэгдсэн системд дээр хугацаа хэтэрсэн зээлийн алданги тооцох мэдлэг ур чадвар байхгүй. Гэрээний хэрэгжилт болон зээлийн эргэн төлөлтийн хуваарьт хяналтыг хэрэгжүүлдэггүй. Мэргэжлийн бус албан хаагчийг томилон үүрэг гүйцэтгүүлсэн, Хоршоог хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулдаггүй зэргээс тус тус шалтгаалсан байна.
Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Сангийн хөрөнгө бүрэн төвлөрөхгүй байх, сангийн хөрөнгийн үр ашгийг бууруулж санг алдагдалд оруулах, зээлийн гэрээний хэрэгжилт хангагдахгүй байх, муу зээлийн ангилал нэмэгдэх,
Зөвлөмж	Зээлийн нэгдсэн санд хугацаа хэтэрсэн зээлдэгчдэд журам болон гэрээнд заасны дагуу алдангийг сар бүр тооцож хэвших.
Илэрсэн асуудал 4.	Барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүй байхад сангаас зээл олгосон байна.
Асуудлын ангилал	Их
Бодит байдал	7 сумын ХХС-аас олгосон нийт 44 зээлдэгчийн барьцаа хөрөнгө шаардлага хангахгүй байна. Үүнд: Алтанбулаг, Баруунбүрэн, Сайхан, Сүхбаатар, Хушаат, Хүдэр, Шаамар сумдын нийт 44 зээлдэгчийн 210,497.0 мянган төгрөгийн зээл барьцаа хөрөнгийн шаардлага хангаагүй сумууд байна.
Байх ёстой шаардлага /шалгуур	ХХААС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалын 3.4.4-д "энэ журмын 3.4.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргуулах бөгөөд үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх", 6.3.3-д "зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх", 6.4.4-д "төслийн зээлийн мөнгөн дүнд хүрэлцэхүйц барьцаа хөрөнгөтэй байх"

Асуудлын шалтгаан үндсэн	Барьцаа хөрөнгийн шалгуурт тавигдах зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгийн үнэлж аваагүй, зах зээлийн үнэлгээг бодитоор тооцоогүй, зээлийн мөнгөн хүнд хүрэлцэх үнэ бүхий хөрөнгийг барьцаалаагүйгээс шалтгаалсан байна. ж/нь (Барьцаа хөрөнгөд ямар үл хөдлөх хөрөнгөгүй, хоосон зах зээлийн үнэлгээ тодорхойгүй эзэмшлийн газар, хуучин тээврийн хэрэгсэл, мал зэрэг хөрөнгийг үнэлүүлж зээл авсан.)
Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлийн үлдэгдлийг барьцаа хөрөнгөөр хангуулах боломжгүй байгаа сангийн хөрөнгийг алдагдалд оруулах хугацаа хэтэрсэн зээлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шүүхийн шийдвэрээр албадан төлүүлэхэд Зөрчлийн хуулийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх шалтгаанаар шийдэгдэхгүй байх сөрөг үр дагавар бий болсон байна..
Зөвлөмж	Цаашид барьцаа хөрөнгийн үнэлгээг бодитоор үнэлж шалгуур хангасан тохиолдолд зээл олгож байх.
Илэрсэн асуудал 5.	Зээлийн эргэн төлөлт дуусаагүй байхад барьцаа хөрөнгийг олгосноос зээлийн авлагыг барагдуулах боломжгүй болсон.
Асуудлын ангилал	Их
Бодит байдал	Аудитын явцад зээлийн эргэн төлөлт дуусаагүй байхад 12 зээлдэгчийн барьцаа хөрөнгийг буцаан олгосон зөрчил тогтоогдсон байна.
Байх ёстой шаардлага /шалгуур	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 11.2 Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, энэ журамд заасныг зөрчиж төсөл сонгон шалгаруулсан, төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол тухайн сумын Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэж сангийн хохирлыг барагдуулна. 11.3 Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.
Асуудлын шалтгаан үндсэн	Зээлийн эргэн төлөлт дуусаагүй байхад эрх бүхий албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан Баруунбүрэн суманд 2 зээлдэгчийн 6,800.0 мянган төгрөг, Мандал суманд 2 зээлдэгчийн 55,436.1 мянган төгрөг, Хушаат суманд 2 зээлдэгчийн 13,669.4 мянган төгрөг, Шаамар суманд 6 зээлдэгчийн 19,673.6 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг буцаан олгосноос шалтгаан нөхөн төлүүлэх боломжгүй болсон бол Баруунбүрэн суманд 1 зээлдэгчийн 2,890.0 мянган төгрөг, Хушаат суманд 1 зээлдэгчийн 2,973.9 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг гэрээг үрэгдүүлсэн гэх шалтгаанаар шүүхэд өгөх боломжгүй болсон байна.

Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Сангийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, алдагдалд оруулах сөрөг үр дагаврыг бий болгосон байна.
Зөвлөмж	Шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон гэх үндэслэлээр барьцаа хөрөнгийг олгохгүй байх, Хэрэв олгосон тохиолдолд буруутай албан тушаалтнаар төлүүлж сангийн хөрөнгийн хохирлыг барагдуулах арга хэмжээг авч ажиллах.
Илэрсэн асуудал 6.	Зээлийн хувийн хэргийн бүрдэл дутуу, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавиагүй.
Асуудлын ангилал	Их
Байх ёстой шаардлага /шалгуур	<p>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 6.10.Сумын Засаг дарга зээлдэгчийн талаарх дараах баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгална:</p> <ul style="list-style-type: none"> 6.10.1.зээлдэгчийн анкет; 6.10.2.зээл олгохыг хүссэн өргөдөл; 6.10.3.оршин суугаа газрын тодорхойлолт; 6.10.4.төслийн баримт бичиг; 6.10.5.энэ журмын 3.3.2-т заасан хорооны хурлын тэмдэглэл; 6.10.6.зээлийн болон барьцааны гэрээ; 6.10.7.барьцаа хөрөнгийн үнэлгээний жагсаалт, барьцаалсан үнэ, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувь болон барьцаа хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж барьцаалбал үйлдсэн тухай баримтыг хавсаргана; 6.10.8.зээлийн эргэн төлөлтийн хуваарь; 6.10.9.энэ журмын 6.3, 6.4-т заасан шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг баталгаажуулсан баримт бичиг; 6.10.10.Хоршоо, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, үйл ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөө. <p>6.11.Сумын Засаг дарга энэ журмын 6.10-д зааснаас гадна төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх бусад мэдээллийг тухай бүр баримтжуулан хадгалж, цахим архив үүсгэнэ.</p>
Асуудлын шалтгаан үндсэн	Хууль тогтоомжийг мөрдөөгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Бусдад даваа байдал үүсгэх, Сангийн хөрөнгө бүрэн төвлөрөхгүй байх
Зөвлөмж	Хувийн хэргийн бүрдэл хангаагүй зээлдэгчид зээл олгосон буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж байх, ХХС-аас олгосон зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулж, чанаргүй зээлдэгчдийн ангиллыг бууруулах арга хэмжээг авах.

Илэрсэн асуудал 7.	Сангаас олгосон зээлийн мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлээгүй.
Асуудлын ангилал	Их
Бодит байдал	Жижиг дунд үйлдвэрийн газраас зээлийн эргэн төлөлтийн мэдээг өөрийн албан ёсны цахим хаягаар мэдээллийг олон нийтэд хүргэж байгаа боловч орон нутгийн түвшинд 2022, 2023 онуудад 14 сум, огт мэдээлээгүй байна.
Байх ёстой шаардлага /шалгуур	ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалын 8.3-д "Зээл авсан хоршооны нэр, регистрийн дугаар, шалгарсан төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл, төсөл хэрэгжих байршил, сонгон шалгаруулсан шийдвэрийг Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу байгууллагын шилэн данс, цахим хуудсаараа дамжуулан нийтэд ил тод мэдээлнэ.
Асуудлын шалтгаан үндсэн	Хууль тогтоомжийг мөрдөөгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Бусдад хардагдах, түүнчлэн бусдад давуу байдал үүсгэх
Зөвлөмж	Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн эргэн төлөлтийн талаарх мэдээллийг шилэн дансны цахим хуудас болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан тогтмол мэдээл байх.
Илэрсэн асуудал 8.	Сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлээгүй байхад зээл олгох эх үүсвэрийг баталсан.
Асуудлын ангилал	Дунд
Бодит байдал	Сүхбаатар, Хушаат сумдын ИТХ-ээс сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлээгүй байхад зээл олгох эх үүсвэрийг баталсан байна.
Байх ёстой шаардлага /шалгуур	ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалын 2.10-д "Төсөл сонгон шалгаруулах товыг зээлийн эргэн төлөлт, санхүүжилтийг харгалзан сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно"
Асуудлын шалтгаан үндсэн	Хууль тогтоомжийг мөрдөөгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Сангийн хөрөнгө бүрэн төвлөрөхгүй байх
Зөвлөмж	Сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдээгүй байхад зээл олгохгүй байх.
Илэрсэн асуудал 9.	Тайлант онд сангийн нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлэх

Асуудлын ангилал	Дунд
Бодит байдал	2022 онд 7 сум, 2023 онд 9 сум тайлант онд сангийн нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлээгүй.
Байх ёстой шаардлага /шалгуур	ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалын 7.1-д заасан Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд "жилийн эргэн төлөлтийн нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлсэн байх"
Асуудлын үндсэн шалтгаан	Хууль тогтоомжийг мөрдөөгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Сангийн хөрөнгө бүрэн төвлөрөхгүй байх
Зөвлөмж	Журмын 7.1-д заасан Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд заасан зээлийн эргэн төлөлтийн шалгуурыг хангуулахад хяналт тавин ажиллах.
Илэрсэн асуудал 10.	ХХС-ийн зээл олгох санхүүгийн эх үүсвэрийг үндэслэлгүй нэмэгдүүлэн баталсан.
Асуудлын ангилал	Дунд
Бодит байдал	ХХС-ийн зээл олгох санхүүгийн эх үүсвэрийг тодотгол хийх үндэслэл бүрдээгүй байхад 4 сум нэмэгдүүлэн баталсан
Байх ёстой шаардлага /шалгуур	Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-д "дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон"
Асуудлын үндсэн шалтгаан	Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй.
Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар	Төсвийн тодотголыг үндэслэлгүй хийснээс сангийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж алдагдалд оруулах эрсдэлийг бий болгож байна.
Зөвлөмж	Хууль тогтоомжид нийцээгүй тодотгол хийж сангийн хөрөнгийн зарцуулалтыг нэмэгдүүлэхгүй байх
Илэрсэн асуудал 11.	ХХС-ийн эх үүсвэрийг зориулалтын дагуу зарцуулаагүй.
Асуудлын ангилал	Их
Бодит байдал	ХХС-ийн эх үүсвэрээр хөрөнгө бэлтгэж санхүүгийн тайланд хөрөнгөөр бүртгэсэн 10 сум байна.
Байх ёстой шаардлага /шалгуур	ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалын 1.5-д Сангийн хөрөнгө нь суманд хоршоо санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл сонгон шалгаруулах, хөнгөлөлттэй зээл олгох,

		сургалт зохион байгуулах, хяналт тавих, авлага барагдуулах, урамшуулал олгоход зориулагдана.
Асуудлын шалтгаан	үндсэн	Сангийн хөрөнгийг журамд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй нь аудитын явцад тогтоогдсон
Байгууллагад үзүүлэх нөлөө/үр дагавар		Сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулах сөрөг үр дагаврыг бий болгосон.
Зөвлөмж		Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ХХС-ийн санхүүгийн тайланд бүртгэсэн хөрөнгийг сумын ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд санхүүгийн тайлан хооронд холбогдох зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авч шилжүүлэх.

5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ.

Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, журмын хэрэгжилт хангалтгүйгээс 2023 оны жилийн эцсийн байдлаар сангийн нийт хөрөнгийн 56.1 хувь нь чанаргүй, муу зээлийн ангилалд орсон болон аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн “Хангалтгүй” гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Хангалтгүй	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 1-р түвшин”-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 80%-иас дээш нь “нөлөө ихтэй” гэж үзсэн

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР



Ц.УРТНАСАН

ДОТООД АУДИТОР



Х.БАТБААТАР

ТАЙЛАН ХЯНАСАН:

АХЛАХ ДОТООД АУДИТОР



Т.МӨНХЗУЛ

ТАНИЛЦСАН:

ДАРГА



Т.ОДСҮРЭН